



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

Ё.Нямжавыг ажлаас чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 39 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ёндоншаравын Нямжавын ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг харгалзан үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөр дуусгавар болгосугай.

2.Ё.Нямжавтай санхүү, эд аж ахуйн холбогдох тооцоог хийж, тогтоолыг хэрэгжүүлж, ажил хүлээлцэх комисс гарган 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохих журмын дагуу хүлээлцүүлэхийг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3.Дэд захирал Д.Хулганажаваар тус үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг хавсран гүйцэтгүүлж, санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсэг зурах, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрхийг олгосугай.


4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000820